



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1082  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Дүгнэлт хүргүүлэх тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох “Зүй ёс нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

**Дүгнэлт**

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор “Зүй ёс нам”-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Зүй ёс нам”-ын мөрийн хөтөлбөр /.....8.....хуудас/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan\_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001930684



## “ЗҮЙ ЁС НАМ”-ЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР 2024 оны Улсын Их Хурлын сонгууль

Зүй Ёс Нам нь төв үзлийг баримталсан улс төрийн нам юм.

Үнэт Зүйл

Бид зүй ёсыг бүрдүүлэгч **Эрх чөлөө-Тэгш боломж, Эрх зүйт төр-Шударга ёс, Эрдэм боловсрол-Эв нэгдлийг** эрхэмлэн дээдэлнэ.

### Эрхэм Зорилго

Нийгмийн ардчилал, хүний эрх чөлөөг бататган, зүй ёсыг дэлгэрүүлэх замаар улс орноо цогцлуулан хөгжүүлэх нь Бидний эрхэм зорилго мөн.

### Намын Зарчим

Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, язгуур эрх ашгийг дээдлэн, хууль ёс, ёс суртахууны хэм хэмжээг сахиж, мэдлэг чадварт тулгуурлах нь “Зүй Ёс” Намын үйл ажиллагааны үндсэн зарчим байна.

### Оршил

Монгол Улсын хөгжлийн төлөө Монгол иргэн бүрийн нөөц бололцоо, эв нэгдэл, итгэл сэтгэл, зүтгэлийг нэгтгэж, шударга төр, шударга нийгэм, шударга боломж, баялгийн шударга хуваарилалтыг хүн бүр, нийгмийн эд эс бүрд тэгш хүргэнэ.

Ардчилал, зах зээлийн шилжилтийн жилүүдэд улс төр, нийгэм, эдийн засагт үүсэн буй болсон ардчиллын гажуудлыг засч залруулан, Хууль ёсыг сахиж амьдардаг иргэн хүн бүр сэтгэл амар, итгэл дүүрэн, нэр төртэй, сайн сайхан амьдардаг, иргэн бүр бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэдэг, зүй ёс, шударга ёс ноёлсон нийгэм байгуулна.

Хөдөлмөрлөсөн нь сайхан амьдардаг, хичээсэн нь амжилт гаргадаг, боломж чадвараар дутуугаа гээдэггүй, шударга нийгмийг цогцлон байгуулна. Улсын үндэс, эзэд нь болох иргэн, гэр бүл, ахмад үе, хүүхэд балчраа хайрлан дээдэлнэ.

Иргэн бүрд жигд боломж, нөхцлийг олгосон баялгийн шударга хуваарилалтыг хэрэгжүүлж, авлигаас ангид бие даасан, хэсэг бүлэг этгээдийн шунал, хүсэлд захирагддаггүй, сахилга баттай шударга чөлөөт зах зээлийн эдийн засгийг бий болгоно.

Чадварлаг цомхон засгийн газартай байж, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбод, иргэдийн оролцоо, хяналт тавих эрх, эрх чөлөөг нэмэгдүүлнэ.

Дэлхийн бусад улсуудтай шударга, тэгш зарчмаар харилцана. Монголын давуу талыг Дэлхийд таниулж, Дэлхий дахины хүний эрх, байгаль орчин, энх

 00000001<sup>1</sup>

тайвныг хамгаалан бэхжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулна. Монголын тусгаар байдлыг эрхэмлэн дээдэлж, бүс нутгийн хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулна.

“Зүй Ёс” Нам нь иргэд нь эрдэм боловсрол, ёс суртахуунтай, үндэсний бахархал, эв нэгдэлтэй байж, Монгол хүний хөгжлийн төлөө хойч ирээдүйн хүлээлт, ирэдийн итгэл найдварт бүрэн гүйцэд хариулах үндэсний уламжлалаа хадгалсан шинэ хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ.

Үндэсний өв соёл, түүх, нүүдэлчдийн ахуй, байгаль зүйн өвөрмөц онцлог хэв шинжийг хадгалан хайрлахын зэрэгцээ дэлхийн дэвшилтэт сайн туршлагаас бүтээлчээр суралцаж, дэлхий дахинд улс орноо эерэгээр сурталчлан таниулах зэрэг зөөлөн хүчний цогц бодлогоор Итгэл найдвар, Эв нэгдлийг сэргээн хамгаална.

“Зүй Ёс” Нам нь нийгэм, эдийн засгийн дараах бодлогуудыг авч хэрэгжүүлнэ.

### **НЭГ. Эрх зүйт төр, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө**

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг Монгол Улсад бодитоор хангах, шүүх, хууль сахиулах байгууллагуудын засаглалын оновчтой хэлбэр, тогтолцоог чандлан хамгаалж, хуулиа дээдлэх зарчмыг хэрэгжүүлнэ.

Ардчилал, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, хууль ёс, сахилга батыг дээдлэн, эрх зүйн орчин оновчтой, шударга байхад анхаарч, шударга ёсыг сахиулна.

Шүүх, прокурор, цагдаа зэрэг хууль хүчний байгууллагуудыг улс төрөөс хараат бус, ёс зүйн дүрэмтэй, хариуцлагатай, стандарттай байж, иргэдэд шударгаар үйлчлэх улс төр, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Хууль эрх зүйн хэрэгжилт муу, шүүхийн шийдвэр хэрэгжихгүй удааширч байгаа байдлыг залруулж, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, иргэний хөдөлгөөн, иргэдийн оролцооны зохистой хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.

Хууль эрх зүйн талаарх суурь мэдлэгийг ерөнхий боловсролын сургуульд олгодог болно.

Хууль эрх зүйн туслалцаа авах боломжийг иргэн бүрд тэгш олгож, орчин үеийн мэдээллийн технологийг нэвтрүүлэх замаар гадаадад байгаа иргэдийнхээ сонгох, сонгогдох эрхийг хангана.

Мэдээллийн технологийг ашиглаж гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэддээ төрийн үйлчилгээг хүргэх, сонгуулийн болон бусад Үндсэн хуулиар олгогдсон иргэний эрхээ эдлэх боломжоор үргэлж хангана.

Төрийн зарим эрх үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн салбарт шилжүүлэх, бодлогын түвшин дэх оролцоог нэмэгдүүлнэ.

### **ХОЁР. Тэгш боломж, Шударга өрсөлдөөн**

  
00000002 2

Бид хүний эрх, эрх чөлөө, ардчилал, шударга ёсыг дээдлэн сахиж, төрийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, ил тод, хариуцлагатай байлгана. Төрийн албыг улс төрөөс ангид, мэдлэг, чадварт суурилсан шударга, ёс зүйтэй хүний нөөцөөр бэхжүүлж, иргэдийн хяналтыг нэмэгдүүлж, хүнд суртал, авилгатай тууштай тэмцэнэ.

Төрийн үйлчилгээг бүрэн цахимжуулж, блокчэйн, хиймэл оюун зэрэг мэдээллийн шинэ технологийг үр ашигтай ашиглан шуурхай, ил тод болгоход анхаарна. Төрийн үйл ажиллагааны шийдвэр эрх зүйн хэм хэмжээ, актад суурилсан байхад анхаарч, бодлогын судалгааны хүрээлэн, эрдэмтэн мэргэдийн зөвлөл, хиймэл оюуныг түлхүү ашиглахыг зорино.

Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, тогтвортой хөгжилд суурилсан эдийн засгийг бий болгож, байгаль орчноо дээдэлж, улс орныхоо давуу тал, иргэдийн оюун ухаан, ур чадвар, инновацид түшиглэсэн дэлхийд өрсөлдөх чадвартай дэвшилтэт технологи бүхий үндэсний аж үйлдвэр, үйлдвэрлэл, үйлчилгээг түлхүү дэмжин хөгжүүлнэ.

Төр, шинжлэх ухаан, боловсрол, бизнесийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.

Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн сайжруулж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар эдийн засгийг тэлнэ. Бага хүүтэй, урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээл, зээлийн батлан даалтын сангийн хүртээмжийг нэмэгдүүлснээр жижиг дунд аж ахуй нэгжүүдийг дэмжиж, импортыг орлуулах, экспортыг нэмэгдүүлэх, үндэсний бренд бий болгох ажлыг бүхий л талаар дэмжинэ.

Засгийн газрын худалдан авалт, тендерийн шударга хэрэгжилтийг хангана.

Банк санхүү, төлбөрийн тооцоонд шинэчлэл хийж шударга, нээлттэй болгоно. Төгрөгийн ханшийг тогтвортой, зээлийн хүүг бууруулах боломжийг эрэлхийлж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.


Бизнесийн салбарт бизнес эрхлэх шударга, тогтвортой орчинг бүрдүүлнэ. Компаниудын засаглал, ёс зүйг сайжруулах, зөвлөх үйлчилгээг дэмжих бодлого хэрэгжүүлнэ. Ажил олгогч болон ажилтны харилцааг ёс зүйтэй, харилцан эрх тэгш байх боломжийг бүрдүүлж, ажилтан хүний эрх хамгаалагддаг, ажилтан хүн айх айдасгүй, элдэв доромжлол, гүтгэлэг, дарамтаас ангид байдаг эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

### **ГУРАВ. Эрдэм Боловсрол, Эв нэгдэл**

Хүүхэд залуучуудыг шударга ёсыг эрхэмлэдэг, өөртөө итгэлтэй, бие дааж шийдвэр гаргадаг, үндэсний бахархалтай, дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг чадвартай, авьяаслаг иргэн болгон өсгөн хүмүүжүүлэх нь манай намын тэргүүлэх зорилт байна.

Иргэн бүр бага балчраасаа эхлэн бие биенээ хүндэтгэх, эрх үүргээ ухамсарлах, харилцаа, мэтгэлцээний өндөр соёлтой, түүх соёлоо мэддэг, үндэсний бахархалтай, эх оронч өв тэгш хүн болж хүмүүжихэд анхаарч, боловсрол, сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулна.

Хүндлэх, хүндлүүлэх, харилцан итгэлцэх, бусдад эерэг хандлагатай, эрүүл саруул нийгмийн хүрээлэл дунд ажиллаж, амьдрах оюун санааны хэрэгцээг

3  
00000003  




Ядуурлыг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх, цалин хөлс, өрхийн орлогыг тасралтгүй нэмэгдүүлэх бодлого баримтална. Дотоодын нөөц бололцоогоор хийх боломжтой ажлын байрыг хамгаалж, өөрийн орны иргэдийг ажиллуулах, эрэлт хэрэгцээ өндөртэй болон ирээдүйд шинээр бий болох ажлын байруудад боловсон хүчнийг сургах, бэлтгэх бодлого баримтална.

Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, улс орныхоо ирээдүйн төлөө хамтдаа үүрэг хариуцлага үүрэх нөхцөл бололцоог бүрдүүлнэ.

Монгол залуусын хөгжингүй орнуудад сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх замаар мэдлэг ур чадвараа дээшлүүлэх явдлыг хөхүүлэн дэмжихийн хамт эх орондоо эргэн ирж ажил хөдөлмөр эрхлэх, гэр бүлийн хамт элэг бүтэн, аз жаргалтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

### **ТАВ. Эрүүл мэндийн үйлчилгээ**

“Зүй Ёс” Нам нь эрүүл мэндийн үйлчилгээ, тогтолцоог нийгмийн өмнө тулгамдаж буй тэргүүлэх чиглэлийн бодлогын чухал хэсэг гэж үзэн онцгойлон анхаарна. Үүнд:

Эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын ачаалал, ур чадвар, мэргэшил, ажлын үр дүн, ажилласан жил зэргээс хамаарсан цалин хөлс, урамшууллын ил тод, шударга тогтолцоог бий болгоно. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн өмнөх сургалтыг салбарын бодлого, хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээтэй уялдсан хүний нөөцийн төлөвлөлттэй нийцүүлэн эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран шийдвэрлэдэг болгоно.

Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтны төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог сайжруулж, сургалтын түшиц эмнэлгийн сүлжээг байгуулах, сургалтын үйл ажиллагааны мэргэжлийн нийгэмлэг, холбоодод суралцагчийн оролцоог нэмэгдүүлнэ. Нэн шаардлагатай мэргэшлээр эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, орон нутгийг эмнэлгийн мэргэжилтнээр хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах арга хэмжээг хэрэгжүүлэх боломж, нөхцлийг эрэлхийлнэ.

Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах боломжийг эрэлхийлж, эрүүл мэндийн салбарыг авлигаас ангид болгоно.

Эрүүл мэндийн даатгалыг иргэдэд үр өгөөжөө өгдөг байхад анхаарч, нийтийн эрүүл мэндийн анхан шатны мэдлэг, боловсролыг ерөнхий боловсролын сургуульд олгодог болно.

### **ЗУРГАА. Үндэсний аюулгүй байдал, Гадаад бодлого**

“Зүй Ёс” Нам нь төрийн анхдагч үүрэг болох Монгол Улсын Тусгаар тогтнол, Бүрэн эрхт байдал, Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудалд онцгой анхаарна. Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны үндэс нь иргэдийн эх оронч үзэл, улс, үндэснийхээ ирээдүйн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулах чин эрмэлзэл, идэвхтэй үйл ажиллагаа байна.

00000005<sup>5</sup>

Монгол Улсын иргэн бүр үндэсний үнэт зүйлээрээ бахархах, хайрлан хамгаалж, тээн хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, залуу үеийг сурган хүмүүжүүлэх, нийгмийн соён гэгээрүүлэх, иргэдэд аюулгүй байдлын асуудлаар өргөн мэдээлэл, мэдлэг олгох, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт өөрсдийн хувь нэмрийг оруулах боломжоор хангана.

Үндэсний аюулгүй байдлыг хангах засаглалын тогтолцооны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, хүний аюулгүй байдлыг төрийн аюулгүй байдлын хойно оруулсан алдаа, гажуудлыг залруулах үзэл баримтлал, хууль зүйн шийдлийг гаргана.

Газрын тос, хүнс, өргөн хэрэглээний барааны импортын хэт хамааралтай, түүхий эдийн экспорт голлосон, байгалийн баялаг, нөөцөд тавих хяналт алдагдсан, үндэсний үйлдвэрлэл, хөдөлмөрийн нөөц доройтсон, үнийн өсөлтөд өртөмтгий, газар зүйн хувьд түгжигдмэл зэрэг хэт өрөөсгөл, эмзэг бүтэц бүхий Монгол Улсын эдийн засаг нь аюулгүй байдалд тулгамдсан гол асуудал болохыг онцгой анхаарна.

Эдийн засгийн аюулгүй байдалд аюул учруулж буй гадаад, дотоод сөрөг хүчин зүйлүүдийг саармагжуулах, тэдгээрийн эсрэг дархлаа суулгах арга хэмжээг авч, амь бөхтэй, эмзэг бус, бие даасан эдийн засагтай болгох бодлогын цогц арга хэмжээ авч, зөв зохистой тогтолцоог бүрдүүлнэ.

Гадаадын хөрөнгө оруулалт, даяарчлал, хиймэл оюун ухаан, аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал, шинэ техник технологийн Монгол Улсад учруулах аюул, сөрөг нөлөөг судалж, урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.

Гадаад бодлого нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах үндсэн арга гэж үзэж, Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалыг сахин хэрэгжүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын Үндэсний язгуур эрх ашгийг хүндэтгэх бүхий л Гадаад улстай найрсаг харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

“Эдийн засагжсан гадаад бодлого”-ыг бүс нутаг, дэлхийн хамтын ажиллагааны голлох байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд бэхжүүлнэ. Мөн Үндэсний язгуур эрх ашгийг улс төр, эдийн засаг, дипломатын олон тулгуурт идэвхтэй бодлогын хүрээнд хангаж ажиллах төрийн байгууллагуудын тогтолцоог бэхжүүлэх, хөрш орнуудын найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг шат ахиулахын зэрэгцээ “Гуравдагч хөршийн бодлого”-ын ач холбогдолд онцгойлон анхаарна.

Энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалж, бататган бэхжүүлэх, цаг агаарын дулаарал, цөлжилт, хүнсний хомстол, ядуурал зэрэг хүн төрөлхтний хөгжлийн асуудлуудыг өргөн хүрээнд харж, улс орон бүс нутагт хамтран ажиллаж, дэлхийн хамтын нийгэмлэгийн тэгш эрхт гишүүнийхээ нэр хүнд, жин нөлөөгөө улам бататгаж, бүс нутаг, тив дэлхийн хэмжээний идэвхтэй тоглогч байна.

Мөнхийн хөрш болох ОХУ, БНХАУ-тай тогтоосон харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, Стратегийн түншлэлийг бэхжүүлэхийн хамт хөгжингүй орнуудтай “Гуравдагч хөрш”-ийн бодлого, “Түншлэлийн харилцаа”-ны хүрээнд тэдний бодит эрх ашгийг Монголдоо болон бүс нутагт анхаарах, дэмжих замаар гадаад харилцааг тэнцвэржүүлэх бодлогыг тууштай явуулна.

Гадаад бодлогыг эдийн засагжуулах, гадаад оронд оршин суух, зорчих иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, дэлхийн монголчуудын оюун ухаан, мэдлэг, чадварыг Монгол орны хөгжил цэцэглэлтэд эерэгээр ашиглах арга механизмыг байнга эрэлхийлнэ.

## **ДОЛОО. Шинэ аж үйлдвэр**

Мэдлэг оюунд суурилсан технологийн салбарыг тэргүүлэх ач холбогдол өгч, тээврийн зардал бага шаарддаг, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг түлхүү хөгжүүлэн, салбаруудын зохистой харьцааг бий болгох аж үйлдвэрийн бодлогыг баримтална.

Монголд үйлдвэрлэгдэх боломжтой бараа бүтээгдэхүүний зах зээлийг хамгаалах замаар дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.

Хоёр их гүрний дунд хашигдсан, далайд гарцгүй, хүйтний улирал нь урт, дэд бүтэц нь сул хөгжсөн, усны нөөц багатай зэрэг харьцангуй сул талаа саармагжуулж, цахилгааны үнэ хямд, интернетийн хэрэглээ өндөр, гадаад суралцагсдын тоо олон зэрэг давуу талуудаа ашиглан, мэдлэг оюунд түлхүү суурилсан, тээврийн зардал бага шаардах нэмүү өртөг сайтай, эдийн засгийн үр ашиг өндөртэй аж үйлдвэрийг түлхүү хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

Дотоодын түүхий эдийг боловсруулах, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөнгөн аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлийг дэмжинэ. Барилгын материалын үйлдвэрлэлийг тууштай дэмжинэ.

Монголын онцлог, нөхцөлтэй уялдуулан аялал жуулчлалын олон талт хэлбэрийг хөгжүүлэх, гадаадын оршин суугч, зорчигч, жуулчдын жил тойрон Монголд зорчих тааламжтай нөхцөлийг хангах бодлого баримтална.

Уул уурхайн түүхийн эдийн нэмүү өртгийг сайжруулах, гүн боловсруулахад орчин үеийн технологи, удирдлага менежмент, стандарт аргачлалыг нэвтрүүлж, экспортыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. Байгальд ээлтэй, эдийн засгийн өгөөжтэй төмөрлөгийн жижиг оврын үйлдвэрлэл, нефть, нүүрсний боловсруулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.

Монгол Улсын эрчим хүчний системийн найдвартай байдлыг дээшлүүлж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, төслийн санхүүжилтээр шинэ эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлнэ. Монгол Улсад баялаг нөөцтэй нүүрс болон сэргээгдэх эрчим хүчийг түлхүү ашиглаж, дунд бага оврын бие даасан эрчим хүчний үйлдвэрлэл явуулах бодлогыг баримтална.

Олон улсын болон орон нутгийн авто зам, агаарын тээвэр, төмөр зам, энерги, эрчим хүчний нэгдсэн сүлжээ, транзит тээврийг хөгжүүлнэ.

Гадаад улсын иргэдэд ээлтэй амьдрах, аялах нөхцөлөөр хангаж, тааламжтай эрүүл мэндийн үйлчилгээ, аюулгүй амар тайван байдлыг хангана. Өвөл, хавар намрын аялал жуулчлалыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

## **НАЙМ. Хот байгуулалт, амьдрах орчин**



Монгол Улсын нийслэл хотыг уламжлалт өв соёлын үнэт зүйлдээ хүндэтгэлтэй хандан, хүнээ эрхэмлэн дээдэлсэн, газар нутгийнхаа онцлогт зохицсон, байгаль орчинд ээлтэй урт хугацааны оновчтой бөгөөд тогтвортой хот төлөвлөлтөд суурилж, эрүүл, аюулгүй амьдралын таатай орчин бүрдүүлсэн, иргэд хувийн хэвшлийн зохистой оролцоог хангасан, сайн засаглал бүхий орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан, бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангасан их хот болгон хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

Мөн Нийслэл хотоо төсөв санхүү болон хэрэглээний бүхий л төрлийн ухаалаг шийдлийг дэмжин нэвтрүүлж хэрэгцээнээс илүү төлөвлөлтгүй, илүү зардалгүй, хэмнэлттэй, ухаалаг, хүрээлэн буй орчинд ээлтэй, эдийн засгийн эрч хүчтэй хот болгон хөгжүүлнэ.

Хот суурин газрын хүрээлэн буй орчны бохирдол, хатуу болон зөөлөн дэд бүтцийн хүртээмжгүй байдал гэх мэт тулгамдсан асуудлуудыг оновчтой шийдвэрлэн, хүн амын хурдацтай өсөлтийг даган тасралтгүй нэмэгдэх хэрэглээг хязгаарлагдмал нөөцөөр хангах явцдаа хүрээлэн буй орчин болон иргэдэд ээлтэй, аюулгүй, амьдрахад таатай, өрсөлдөх чадвартай, эрч хүчтэй хотуудыг бий болгон хөгжүүлнэ.

### **ЕС. Хүнс, хөдөө аж ахуй, хөдөө орон нутгийн хөгжлийн бодлого**

Хүн ам цөөтэй, эх газрын эрс тэс уур амьсгалтай, экологийн эмзэг орчин бүхий уул, тал хээр, говь цөл хосолсон өргөн уудам нутагтай Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлж, засаг захиргааны олон жижиг нэгжийг томсгон, сум дундын болон аймгийн, бүсийн төвүүд зэрэг хот суурин газрыг хөгжүүлснээр хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгана.

Байгаль орчны даац, чадавхид нь тохируулан бэлчээрийн мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуй, аялал жуулчлал, орчин үеийн суурин соёл иргэншил, техник технологийн ухаалаг ололт, газар тариалан, жижиг дунд үйлдвэр, түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлтэй зохистойгоор хослуулан хөдөлмөрийн бүтээмж, үржил шимийг дээшлүүлнэ. Газар тариалан, мал аж ахуй эрхлэгчдийн хөдөлмөрийг хялбаршуулах, хорших зөв хэлбэрийг олж нэвтрүүлнэ.

Хөдөөгийн хүн амын хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, соёл, урлаг, мэдээлэл, ахуйн үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ.

Хөдөө орон нутгийн өөртөө засах эрхийг нэмэгдүүлж, зарим төрлийн татварыг хөдөө орон нутгийн хөгжилд зарцуулах эрхийг тухайн орон нутагт нь олгох, тухайн бүсийн байгалийн баялгийн нөөцийг ашигласны эцсийн үр өгөөжийг ахиу хүртээх, байгаль орчныг хамгаалах нийтлэг асуудлыг аймаг, сум, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хамтын хүчээр шийдвэрлэж экологийн тэнцвэртэй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх зорилт тавьж, иргэдийг эрүүл, баталгаат хүнсээр хангана. Үндэсний онцлогийг харгалзсан органик, уламжлалт бүтээгдэхүүний экспортыг дэмжин хөдөө аж ахуйн салбарт бизнес эрхлэгчдийн тогтвортой үйл ажиллагааг хангана.

Зүй ёс дэлгэртүгэй